

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨНД ОЛГОСОН
ЗЭЭЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТ, ҮР ДҮН"

АУДИТЫН КОД: ДУА-2026/21-10/ШТА-ГА

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn Ахлах
аудитор: Ж.Угтахбаяр
Аудитор: Д.Должинсүрэн, Э.Пүрэвбаатар,
Б.Сарангуа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын тайланг баталгаажуулах тухай	
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгс	4
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>БҮЛЭГ 1. ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ НИЙЦСЭН БОЛОВЧ ОРОН НУТАГТ ТУСГАЙЛСАН САНХҮҮЖИЛТ БАТЛААГҮЙ БАЙНА.</u>	7-8
Аудитын менежер Т.Батсайхан	1.1 Орон нутагт зохион байгуулалттай холбоотой төсөв баталж, хуваарилаагүй байна.	7-8
Ахлах аудитор Ж.Угтахбаяр	<u>БҮЛЭГ 2. ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ НЬ ХОРШООГ БИЕ ДААСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭР ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗОРИЛГОД НИЙЦЭЭГҮЙ, ЗЭЭЛИЙН ШАЛГУУР, ЗОРИУЛАЛТЫН АШИГЛАЛТ, ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА</u>	8-14
Аудитор Д.Должинсүрэн	2.1.Холбогдох хуулийн дагуу хоршоо нь шинээр үүсгэн байгуулагдсан боловч зээлийг хоршооны дансаар бус гишүүний хувийн дансаар олгосон нь хоршоог бие даасан хуулийн этгээд болгон төлөвшиүүлэх зорилго хангагдахгүй байна.	8-10
Э.Пүрэвбаатар	2.2. Хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хэвийн байгаа ч зарим шалгуур хангаагүй хоршооны гишүүнд зээл олгосон, зориулалтын ашиглалт, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.	10-14
Б.Сарангуа	Дүгнэлт	15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Зөвлөмж	16
ХАЯГ:	Дээд байгууллагад хүргүүлэх санал	17
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот	Санал, тайлбар	18
2026 оны 06 дугаар сар	Хавсралт	19-22



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 1/22

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18 дугаар зүйлийн 9, 2025 оны А/175 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1, 3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг /ДУА-2026/21-10/ШТА-ГА/-г баталсугай.


2. Аудитаар илэрсэн зөрчил, албан шаардлага, зөвлөмжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Хаан банк, Төрийн банк болон Статистикийн хэлтсийн дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2026 оны 11 сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга С.Мөнхчулуун, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Л.Уранбилэг, Статистикийн хэлтсийн дарга Б.Энхтуяа, Хаан банкны салбарын захирал Д.Ганмятмар болон Төрийн банкны салбарын захирал Э.Хөхөөхүү-д тус тус зөвлөсүгэй.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-д (Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ) заасан.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор Ж.Угтахбаярт үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

4826010050

ДУА-2026/21-10/ШТА-ГА

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУС	Монгол Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны тоо
Хүснэгт №1	Зээлийн олголт, төлөлт	9
Хүснэгт №2	Арилжааны банкуудын хяналт	10
Хүснэгт №3	Зээлийн зориулалт	11

ЗУРАГЛАЛ

№	Тайлбар	Хуудасны тоо
Зураглал №1	Хоршоодын санхүүгийн тайлан гаргасан байдал	8
Зураглал №2	Мал бүхий иргэнд олгосон зээлийн мэдээлэл	9
Зураглал №3	Зээлийн олголт, төлөлт, олгосон зээлийн тоо /онуудаар/	10

ГРАФИК

№	Тайлбар	Хуудасны тоо
График №1	Хоршооны тоо сумдаар	7

	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
<i>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</i>	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэх аудитын сэдэв, МҮЕА-ын 2025 оны А/179 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө.
<i>Аудитын зорилго, зорилт:</i>	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хүрээнд хоршооны гишүүн малчдад олгосон зээл нь Шинэ сэргэлтийн бодлогын холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлэхэд нөлөөлж байгаа эсэх, малчдад дэмжлэг үзүүлэхүйц хэмжээтэй байгаа эсэх, зориулалтын дагуу ашиглаж, үр дүнд хүрсэн эсэхэд аудит хийж, аудитын дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.
<i>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:</i>	Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Төрөөс Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнд суурилан боловсруулагдаж, хэрэгжиж байгаа эсэх; - Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцсон эсэх; Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд: - Төрийн аудитын тухай хууль; - Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль; - Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль; - Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль; - Хоршооны тухай хууль; - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль - Иргэний хууль; - Банкны тухай хууль; - Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль;
<i>Аудитын хамарсан хүрээ:</i>	Аудитад Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолоор "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Тус аудитын хүрээнд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Монголбанкны салбар, Статистикийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хаан банк, Төрийн банк болон Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд зээл авсан 519 хоршооны 1,817 малчдыг хамруулан гүйцэтгэлээ.
<i>Аудитын арга зүй:</i>	Аудитыг АДБОУС 100, 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын багц стандарт MNS 6817-2020 “Төрийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа	тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.
	Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Батсайхан хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Угтахбаяр, аудитор Д.Должинсүрэн, Э.Пүрэвбаатар, Б.Сарангуа нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрүүдэд гүйцэтгэлээ.
	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг УИХ-аас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталж, 4 дүгээр сарын 24-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
	“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 166 дугаар тогтоолоор “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэхээр баталсан. Дээрх тогтоолын хавсралтаар 5 (тав) их наядын “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг 2 чиглэлийн хүрээнд 13 арга хэмжээг тусгасан байна. Дундговь аймгийн хэмжээнд 519 хоршооны 1,817 малчдад 61,348.6 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд нийт зээлийн хамгийн их буюу 14.0 хувийг Сайнцагаан, 11.2 хувийг Адаацаг сумдын малчдад, хамгийн бага 1.5 хувийг Дэлгэрхангай, 2.1 хувийг Сайхан-Овоо сумдын хоршооны гишүүн малчдад олгосон байна.
Үндсэн мэдээлэл	



БҮЛЭГ 1. ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ НИЙЦСЭН БОЛОВЧ ОРОН НУТАГТ ТУСГАЙЛСАН САНХҮҮЖИЛТ БАТЛААГҮЙ БАЙНА.

1.1. Орон нутагт зохион байгуулалттай холбоотой төсөв баталж, хуваарилаагүй байна.



Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийн ач холбогдол, үр нөлөөг орон нутагт сурталчлан таниулах, арга хэмжээг идэвхжүүлэх чиг үүргийг аймаг, сумдын Засаг дарга нарт хүлээлгэсэн боловч Дундговь аймагт уг чиг үүргийн хүрээнд тусгай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулаагүй, тайлан мэдээ гаргаагүй байна. Мөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн байгууллагад тусгайлсан төсөв, санхүүжилт хуваарилаагүй байна.

Энэ нь "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулахад чиглэсэн төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын тогтолцоо бүрдээгүй, мөн орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлон хуваарилах зохицуулалт хангалтгүй байсантай холбоотой байна.

Засгийн газрын тогтоолоор хүлээлгэсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийн зорилго, ач холбогдлыг иргэд, хоршоодод үр дүнтэй сурталчлан таниулах, малчдын оролцоо, санаачилгыг нэмэгдүүлэх, бодлогын хэрэгжилтийн үр дүнг орон нутгийн түвшинд үнэлж тайлагнах ажил хангалтгүй хэрэгжиж, арга хэмжээний үр нөлөөг бүрэн хангаж чадаагүй байна.

Иймд аймгийн Засаг дарга нь хоршооны тогтолцооны давуу тал, ач холбогдлыг малчид, иргэдэд сурталчлан таниулах, хоршоодын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүнг тогтмол хянаж, тайлагнаж ажиллах, шаардлагатай төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөн шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Дундговь аймгийн 2024, 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан мал аж ахуйн салбарын арга хэмжээнүүд нь "Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээ"-нд заасан зээлийн үндсэн 14 зориулалтуудтай уялдсан байна. Тухайлбал, бэлчээрийн ус хангамжийг сайжруулах, тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэрлэл хөгжүүлэх, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр, цех байгуулах, мал үржүүлэг, технологийн ажил, мал эмнэлгийн үйлчилгээ, эрчимжсэн мал аж ахуй болон бүтээгдэхүүн хадгалах дэд бүтцийг хөгжүүлэх

чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүд нь хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалтын чиглэлтэй нийцэж байна.

Дундговь аймгийн хөгжлийн бодлого болон малчдад олгож буй хөнгөлөлттэй зээлийн зориулалт хоорондоо уялдсан нь малчдын авч буй зээл зөвхөн хувь хүний санхүүгийн дэмжлэг болоод зогсохгүй, орон нутгийн хөдөө аж ахуйн салбарын дэд бүтэц, эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх стратегийн хөрөнгө оруулалт болох суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна.



БҮЛЭГ 2. ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ НЬ ХОРШООГ БИЕ ДААСАН ХҮУЛИЙН ЭТГЭЭДЭЭР ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗОРИЛГОД НИЙЦЭЭГҮЙ, ЗЭЭЛИЙН ШАЛГУУР, ЗОРИУЛАЛТЫН АШИГЛАЛТ, ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. Холбогдох хуулийн дагуу хоршоо нь шинээр үүсгэн байгуулагдсан боловч зээлийг хоршооны дансаар бүс гишүүний хувийн дансаар олгосон нь хоршоог бие даасан хуулийн этгээд болгон төлөвшүүлэх зорилго хангагдахгүй байна.

"Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд Дундговь аймагт 1,817 малчин өрх нэгдэн, 14 чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор 519 хоршоо байгуулсан байна.

График № 1 Сум тус бүрээрх хоршооны тоог харуулбал дараах байдалтай байна.



Эх сурвалж: Банкны зээлийн судалгаа

Дундговь аймагт шинээр байгуулагдсан дээрх хоршоод дүрэмдээ үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, нэг гишүүний заавал оруулах хувь хөрөнгийн хэмжээг 0.01-1.0 сая төгрөгийн хооронд тогтоожээ. Үүний дагуу дүрэмд тусгагдсан нийт хувь хөрөнгийн хэмжээ 490.8 сая төгрөг байхаар улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.



Аудитаар хоршоодын үүсгэн байгуулах гэрээ, дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ болон холбогдох баримт бичгийг шалгахад Хоршооны тухай хуульд заасан шаардлагын дагуу үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг үүсгэн байгуулах гэрээнд тусгаж, хоршооны дүрмийн "Гишүүний хувь хөрөнгө" хэсэгт гишүүн бүрийн заавал оруулах хувь хөрөнгийн хэмжээг төгрөгөөр тодорхой заасан байна. Түүнчлэн дүрмийн салшгүй хэсэг болох хавсралтад үүсгэн байгуулагч гишүүн бүрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэг бүрчлэн тусган, гарын үсгээр баталгаажуулжээ.

Үүсгэн байгуулах үе шатанд хоршооны нэр дээр дундын данс нээгээгүйгээс үүсгэн байгуулагчдын хувь хөрөнгийг хоршооны ахлагчийн хувийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд зааснаар хоршоо нь үйл ажиллагааны орлого, ашгаас "Хөгжлийн сан" болон "Болзошгүй эрсдэлээс хамгаалах сан"-г бүрдүүлнэ. Мөн хоршоо нь санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

Аудитаар "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан хоршоод дээрх сангуудыг бүрдүүлээгүй байна.

Зураглал №1. Хоршоодын санхүүгийн тайлан гаргасан байдал



Мөн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодоос 16 хувь буюу 83 хоршоо огт санхүүгийн тайлан гаргаагүй, 81.1 хувь буюу 419 хоршоо "Х" тайлан, ердөө 2.9 хувь буюу 15 хоршоо санхүүгийн тайлангаа аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Энэ нь "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн ерөнхий гэрээний зохицуулалттай холбоотой байна. Тодруулбал, хөнгөлөлттэй зээлийг хоршоонд олгоогүй бөгөөд хоршооны дансаар дамжуулахгүйгээр гишүүн малчинтай байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр зээлийн хөрөнгийг зээлдэгчийн хувийн харилцах дансанд шууд шилжүүлсэн байна.

Үүний улмаас зээлийн хөрөнгө санхүүгийн бүртгэлд тусгагдаагүй, хөрөнгийн хуримтлал, санхүүгийн чадавх нэмэгдээгүй бөгөөд Хоршооны тухай хуульд заасан Хөгжлийн сан, Болзошгүй эрсдэлээс хамгаалах сан-г бүрдүүлэх нөхцөл бүрдээгүй байна.



Мөн санхүүгийн бүртгэл, тайлагнал бодитоор хийгдээгүйгээс ихэнх хоршоо зөвхөн "Х" тайлан гаргах, эсхүл огт тайлан гаргахгүй байх нөхцөл үүссэн байна.

"Шинэ хоршоо – Чинээлэг малчин" арга хэмжээ нь хоршоог бэхжүүлэх зорилготой боловч хөнгөлөлттэй зээлийг хоршоонд бус шууд гишүүн

малчинд олгох шийдвэр нь малчдын хувьд зээлд хамрагдах сонирхолыг дэмжсэн, өрхийн амьдралд эерэг нөлөө үзүүлсэн ч хоршооны үйл ажиллагааг тогтворжуулах боломжийг хязгаарласан байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй хоршоодод хууль, журмын хэрэгжилтийг хангуулж, санхүүгийн бүртгэл, тайлагналын талаар арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт, хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөмжөөр хүргүүлээ.

2.2 Хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хэвийн байгаа ч зарим шалгуур хангаагүй хоршооны гишүүнд зээл олгосон, зээлийн зориулалт, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.

Дундговь аймгийн хэмжээнд 519 хоршооны 1,817 гишүүнд нийт 61,348.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Аудитын хүрээнд зээлдэгчдийн хоршооны гишүүнчлэлийг улсын бүртгэлийн <https://www.opendatalab.mn/-ийн> бүртгэлтэй, малчин эсэхийг аймгийн Статистикийн хэлтсийн мал тооллогын бүртгэлтэй тулган шалгахад нийт зээлдэгчид хоршооны гишүүнээр бүртгэлтэй байсан бөгөөд малчин бус, мал бүхий 19 иргэнд нийт 452.9 сая төгрөгийн зээл олгосон байна.

Зураглал №2. Мал бүхий иргэнд олгосон зээлийн мэдээлэл



Энэ нь банкууд зээл олгохдоо ерөнхий гэрээний 3.3¹-т заасны дагуу E-Mongolia системээс авсан "Малчны тодорхойлолт"-ыг үндэслэсэн боловч уг систем нь "малчин" болон "мал бүхий иргэн"-ийг ялган тодорхойлох боломжгүй байсантай холбоотой байна.

Үүний улмаас журамд заасан шалгуурыг хангаагүй иргэдэд хөнгөлөлттэй зээл олгогдсон бөгөөд төрөөс малчдыг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээний зорилтот бүлэгт санхүүгийн дэмжлэг бүрэн хүрэхгүй байх,

санхүүжилтийн хүртээмж буурах, төсөв болон зээлийн эх үүсвэрийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах зарчим алдагдах эрсдэл үүссэн байна. Хөнгөлөлттэй зээл олгохдоо зээлдэгчийн "малчин" гэсэн шалгуурыг бодитой баталгаажуулах мэдээллийн тогтолцоо хангалтгүй байсны улмаас журамд нийцээгүй иргэдэд зээл олгогдсон нь төрийн байгууллагын E-Mongolia системийн хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байсныг харуулж байна.

Иймд И-Монгол академид УАГ-аар дамжуулан (E-Mongolia системээс "малчин" болон "мал бүхий иргэн"-ий тодорхойлолтыг ялгаж гардаг) болгох талаар саналыг хүргүүлээ.

¹ Энэ гэрээний 3.1.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг Улсын бүртгэлийн гэрчилгээ, төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ "Малчны тодорхойлолт"-оор тодорхойлно.

"Шинэ хоршоо—Чинээлэг малчин" арга хэмжээний хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн хэрэгжилтийг шалгалаа.


Хүснэгт №1 Зээлийн олголт, төлөлт:

Банк	Тоо	Олгосон зээл	Төлсөн /2026.03.31/	Зээлийн үлдэгдэл /2026.03.31 /
Төр	637	22,523.6	3,565.4	18,958.3
Хаан	1,180	38,825.0	5,593.7	33,231.2
Нийт дүн	1,817	61,348.6	9,159.1	52,189.5

Дундговь аймгийн хэмжээнд анх олгосон зээлээс 2026 оны I улирлын байдлаар 9,159.1 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Зээлийн чанарын ангиллаар 1,816 зээлдэгчийн зээл хэвийн, 1

зээлдэгчийн зээл анхаарал хандуулах ангилалд бүртгэгджээ. Мөн тайлант хугацаанд хуваарийн дагуу 8,662.7 сая төгрөгийн зээл төлөгдөхөөр байсан боловч бодитоор 9,159.1 сая төгрөг төлөгдөж, төлбөл зохих дүнгээс 496.4 сая төгрөгөөр илүү төлөгдсөн байна. Энэ нь 24 зээлдэгч өөрийн хүсэлтээр, 1 зээлдэгч банкны санаачилгаар зээлээ хугацаанаас өмнө бүрэн төлж хаасантай холбоотой байна. Зээлийн багцын чанар тогтвортой хадгалагдаж, нийт зээлдэгчид хэвийн ангилалд байгаа нь хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн сахилга бат харьцангуй сайн байгааг харуулж байна.

Зураглал № 3. Зээлийн олголт, төлөлт, олгосон зээлийн тоо онуудаар харьцуулбал:



Эх сурвалж: Банкны зээлийн судалгаа



"Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтад арилжааны банкууд, Монголбанк болон Зээлийн батлан даалтын сан хяналт хэрэгжүүлж, харин бодлогын хэрэгжилт, үр дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Засгийн газар нэгтгэн хянахаар зохицуулсан байна. Аудитын явцад дээрх байгууллагуудын хяналт, шалгалтын тайлантай танилцахад арилжааны банкууд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Гэвч зарим зээлдэгчдийн хувийн хэргийн бүрдэл, зээлийн зарцуулалтыг нотлох баримт хангалтгүй байна.

Хүснэгт № 2 Арилжааны банкуудын хяналт

Үзүүлэлт	Хаан банк (Зайны хяналт)	Төрийн банк (Түүвэр шалгалт)
Нийт олгосон зээл	38.8 тэрбум төгрөг	22.5 тэрбум төгрөг
Хяналтын хэлбэр	Цахим системээр дамжсан зайны хяналт	Газар дээрх түүвэр шалгалт (15 тооцооны төв)
Хамрах хүрээ	1,180 зээлдэгчийн 21.4%	637 зээлээс түүвэрлэсэн
Илрүүлсэн зөрчил	253 алдаа, зөрчил (4 төрлийн)	6 зээлийг буцаан дуудах шийдвэр
Засагдсан байдал	241 зөрчил засагдсан	3 зөрчил засагдсан
Шийдвэрлэгдээгүй асуудал	Зээл олгосны дараах зарцуулалтын хяналт хийгдээгүй	43.9 сая төгрөгийн 3 зээлийг буцаан төлүүлэх үүрэг даалгавар биелээгүй

ХААН банк 15 удаагийн зайны хяналтаар 1,180 зээлдэгч буюу нийт зээлдэгчийн 21.4 хувийг хамруулж, 4 төрлийн 253 зөрчил илрүүлэн 241-ийг арилгуулсан байна.

Төрийн банкны Дотоод аудитын газар 2025 онд 15 тооцооны төвөөс олгосон 637 зээлийг түүвэрлэн шалгаж, 6 зээлийг хугацаанаас өмнө буцаан төлүүлэх, газар дээрх хяналтыг эрчимжүүлэх үүрэг, даалгавар өгсөн бөгөөд Монголбанк болон Зээлийн батлан даалтын сангаас 2025-2026 онд "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг түүвэрлэн шалгаж, зээлийн ашиглалт, зарцуулалтад зайны хяналт хийж, холбогдох үүрэг, чиглэл өгч ажилласан байна.

Аудитаар хөнгөлөлттэй зээлтэй холбоотой 6,973.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь зээлийн зориулалтын зарцуулалтыг бүрэн нотлоогүй, зориулалт бусаар зарцуулсан, дотоод хяналтаар буцаан төлүүлэхээр шийдвэрлэсэн зээлийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зэрэгтэй холбоотой байна. Түүнчлэн "Шинэ хоршоо – Чинээлэг малчин" арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй зээлийг хоршоонд бус шууд гишүүн малчинд олгосон нь хоршооны хяналт, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, банкны эдийн засагчдын хяналтын ачааллыг нэмэгдүүлсэн байна. Үүний улмаас зээлийн зориулалтын зарцуулалтыг бүрэн нотлох, илэрсэн зөрчлийг хугацаанд нь арилгах, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангах хяналтын үр нөлөө буурч, хөнгөлөлттэй зээл зориулалт бусаар ашиглах эрсдэл нэмэгдсэн байна.

Зээл олголтын дараах хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй хэрэгжсэн, мөн хөнгөлөлттэй зээлийг хоршоонд бус шууд гишүүн малчинд олгох зохицуулалт нь хоршооны оролцоо, хяналтыг сулруулсны улмаас хөнгөлөлттэй зээлийн зориулалтын зарцуулалтад 6,973.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.



Аудитаар Хулд, Луус, Адаацаг, Өлзийт, Сайнцагаан сумдад газар дээр нь ажиллаж, нийт 30,499.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 901 зээлдэгчийн хувийн хэрэг, зээлийн зарцуулалт, хөрөнгийн бүртгэлийг холбогдох байгууллагын мэдээлэлтэй тулган шалгахад зээлийн хөрөнгийн дийлэнх хэсгийг үржлийн мал худалдан авах, хороо, бууц барих, техник, тоног төхөөрөмж худалдан авах

зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зориулалтаар ашигласан байна.

Хүснэгт №3. Зээлийг зориулалтаар харуулбал дараах байдалтай байна:

№	Зээлийн зориулалт	Дүн (сая төгрөг)	Нийт санхүүжилтэд эзлэх хувь
1	Үржлийн мал худалдан авах, бойжуулах, борлуулах	20,276.2	66
2	Хороо, бууц худалдан авах, барих, засварлах	6,199.5	20
3	Ачааны автомашин, тусгай зориулалтын техник худалдан авах	1,240.5	4
4	Тоног төхөөрөмжийн шинэчлэл	558.5	2
5	Худаг, уст цэг гаргах	687.4	2
6	Агуулах, зоорь, хөргүүр байгуулах	782.0	3
7	Хашаа, бэлчээр хаших	244.5	1
8	Ажлын байр барих	181.0	1
9	Бусад (ногоон тэжээл, бусад худалдан авалт)	330.2	1
Нийт		30,499.9	100

Аудитаар зээлийн хөрөнгийн зориулалт, хөрөнгийн өмчлөл, бүртгэл, тайлагналын баримтжуулалт хангалтгүй байгааг тогтоолоо. Тухайлбал, үржлийн мал худалдан авсан хэдий ч малын “А” дансны бүртгэлийг бүрэн хөтлөөгүйгээс худалдан авсан малын тоо, төрлийг баримтаар нотлох боломжгүй, мөн автомашин, техник хэрэгсэл, хороо, бууцны өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгүүлээгүй, шинээр барьсан болон засварласан барилга байгууламжийн ашиглалтад орсон байдал, ажлын гүйцэтгэлийг нотлох баримт дутуу байна. Түүнчлэн зарим зээлдэгч зээлийн хөрөнгийг гэрээний нөхцөлийг зөрчин зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд илэрлээ.

Үүнд:

- Үржлийн мал худалдан авах зориулалтаар олгосон 5,018.1 сая төгрөгийн зээлийн хүрээнд худалдан авсан малын тоо, төрлийг малын “А” дансанд бүрэн бүртгээгүйгээс зориулалтын ашиглалтыг баримтаар нотлох боломжгүй;
- 129.0 сая төгрөгөөр худалдан авсан автомашин, техник хэрэгслийн өмчлөх эрхийг зээлдэгчийн нэр дээр шилжүүлээгүй;
- 442.9 сая төгрөгөөр худалдан авсан хороо, бууцны газрын болон өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгүүлээгүй;
- 378.2 сая төгрөгөөр шинээр барьсан хороо, бууцны ашиглалтад орсон болон өмчлөх эрхийн бүртгэлийг хийгээгүй;
- 453.4 сая төгрөгөөр засварласан хороо, бууцны өмчлөл болон ажлын гүйцэтгэлийг нотлох баримт хангалтгүй;
- 3 сумын 6 зээлдэгчийн нийт 99.1 сая төгрөгийн зээлийн хөрөнгийг дансны хуулгын мэдээллээр гэрээний нөхцөлөөс өөр зориулалтаар зарцуулсан байж болзошгүй бөгөөд зориулалтын ашиглалтыг бүрэн нотлох баримт хангалтгүй;

Малын бүртгэлийн А дансны үнэн зөв байдал алдагдаж, зээлийн хөрөнгөөр худалдан авсан малын бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг бодитой бүртгээгүй, түүнд тавих хяналт сул байгаа тул хариуцсан ажилтаны ажлын хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Статистикийн хэлтэст зөвлөмж хүргүүлэхээр боллоо.

Мөн дээрх зөрчлүүд нь “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 2.3-т заасан зээлдэгчийн үүргийн хэрэгжилт хангалтгүй, зээлийн зориулалтын ашиглалт, хөрөнгийн өмчлөл, бүртгэл, тайлагналд тавих хяналт сул байгааг харуулж байна.

Түүнчлэн зээлийн шалгуур, зориулалт, тайлагнал, хяналттай холбоотой зохицуулалт тодорхой бус, хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмол хийгдээгүйгээс зээл үр ашиггүй, хүрэх түвшиндээ хүрээгүй байна.

Иймд зээлийн журмыг боловсронгуй болгож, зээлийг зорилтот бүлгийн малчин өрхөд чиглүүлэн олгох, зориулалтын ашиглалт, хөрөнгийн бүртгэл, тайлагнал, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, мөн үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Анхан шатны баримтаар нотлогдоогүй 6,973.7 сая төгрөгийн зээлтэй холбоотой зарцуулалтын нотлох баримтыг зээлдэгчдээс бүрэн гаргуулан авч, зээлийн зориулалтын зарцуулалтыг баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, баталгаажихгүй тохиолдолд зээлийн гэрээний дагуу буцаан төвлөрүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах талаар арилжааны банкуудад зөвлөмж хүргүүлээ.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Засгийн газрын тогтоолоор хүлээлгэсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийн зорилго, ач холбогдлыг иргэд, хоршоодод үр дүнтэй сурталчлан таниулах, малчдын оролцоо, санаачилгыг нэмэгдүүлэх, бодлогын хэрэгжилтийн үр дүнг орон нутгийн түвшинд үнэлж тайлагнаагүй байна;
- Дундговь аймгийн хөгжлийн бодлого болон малчдад олгож буй хөнгөлөлттэй зээлийн зориулалт хоорондоо уялдсан нь малчдын авч буй зээл зөвхөн хувь хүний санхүүгийн дэмжлэг болоод зогсохгүй, орон нутгийн хөдөө аж ахуйн салбарын дэд бүтэц, эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх стратегийн хөрөнгө оруулалт болох суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна;
- Улсын бүртгэлийн байгууллагаас холбогдох хууль, журмын дагуу бүртгэлийн хяналтыг хэрэгжүүлснээр хоршоодыг үүсгэн байгуулагчдын хувь хөрөнгө, зорилго, эрх, үүрэг, хариуцлага, үүсгэн байгуулах гэрээ, дүрмийг бүрэн тусгаж, бүртгэсэн байна;
- Хөнгөлөлттэй зээлийг хоршооны дансаар дамжуулаагүйгээс 419 хоршоо "Х" тайлан гаргаж, 83 хоршоо санхүүгийн тайлан ирүүлээгүй. Мөн Хөгжлийн сан, Болзошгүй эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх хуульд заасан шаардлага хэрэгжээгүй байна;
- Зээлдэгчийн "малчин" эсэхийг баталгаажуулах мэдээллийн тогтолцоо, цахим хяналт хангалтгүй байсны улмаас хөнгөлөлттэй зээлийн журамд нийцээгүй иргэдэд олгогдсон байна;
- Зээлийн эргэн төлөлтийн хяналт үр дүнтэй хэрэгжсэнээр зээлийн чанар хэвийн түвшинд хадгалагдсан байна;
- Хөнгөлөлттэй зээлийг хоршоонд бус шууд гишүүн малчинд олгосон нь хоршооны хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, зээлийн зориулалтын зарцуулалтад тавих хяналтын үр нөлөөг бууруулсан байна;
- Холбогдох албан тушаалтан малын бүртгэлийн нэмэгдэл, хасагдлын хөдөлгөөнийг "А" дансанд үнэн зөв бүртгэх, малын тоо толгойн мэдээллийн бодит байдлыг хангах хяналт хэрэгжүүлээгүйгээс малын бүртгэлийн үнэн зөв байдал алдагдаж, зээлийн хөрөнгөөр худалдан авсан малын бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг бодитой хянах боломжгүй байна;
- Зээлийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөх эрхийн шилжилт, зориулалтын зарцуулалтыг нотлох баримтын бүрдүүлэлт хангалтгүй, зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан эсэхийг бүрэн нотлох боломжгүй байгаа нь зориулалтын бус зарцуулалтын эрсдэл үүсэх эрсдлийг бий болгож байна;



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

Засгийн газрын тогтоолоор хүлээлгэсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, төлөвлөгөө боловсруулан хоршооны давуу тал, ач холбогдлыг иргэд, малчид, хоршоодод үр дүнтэй сурталчлан таниулах, мөн бодлогын хэрэгжилтийн үр дүнг орон нутгийн түвшинд тогтмол үнэлж, тайлагнах;

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст:

Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй хоршоодод холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, санхүүгийн тайлан гаргах, бүртгэл, тайлагналын талаар арга зүйн зөвлөмж, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд хяналт, хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;


Аймгийн Статистикийн хэлтэст:

Малын бүртгэлийн нэмэгдэл, хасагдлын хөдөлгөөнийг “А” дансанд үнэн зөв бүртгэж, малын тоо толгойн мэдээллийн бодит байдлыг хангах хяналтыг сайжруулан, холбогдох албан тушаалтны хариуцлагыг чангатгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Арилжааны банкуудад:

Зээл олголтын дараах зарцуулалтад тавих хяналтыг эрсдэлд суурилан хэрэгжүүлж, зориулалтын бус зарцуулалт илэрсэн тохиолдолд гэрээний нөхцөлийн дагуу шуурхай шийдвэрлэж, хариуцлагын сайжруулах;

Зээл олголтын газар дээрх хяналтыг эрчимжүүлж, зээлийн зориулалтыг анхан шатны баримтаар бүрэн баталгаажуулах, илэрсэн зөрчлийг гэрээний нөхцөлийн дагуу хугацаанд нь арилгуулах, буцаан төлүүлэх шийдвэрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих;



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал


Үндэсний аудитын газраар дамжуулан И-Монгол академид дараах саналыг хүргүүлж байна.

Нөхцөл байдал-1:

Арилжааны банкууд зээл олгохдоо Ерөнхий гэрээний 3.3-т заасны дагуу E-Mongolia системээс авсан “Малчны тодорхойлолт”-ыг үндэслэн мал бүхий 19 иргэнд нийт 452.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Гэвч E-Mongolia системийн “Малчны тодорхойлолт” нь “малчин” болон “мал бүхий иргэн”-ийг ялган тодорхойлдоггүй тул зээлдэгчийн шалгуурыг бүрэн баталгаажуулах боломжийг хязгаарлаж байна.

Санал-1:

E-Mongolia системийн “Малчны тодорхойлолт”-нд малчин болон мал бүхий иргэнийг ялгадаг болгож, программын сайжруулалтыг хийх.



Санал, тайлбар



ДУНДГОВЬ АЙМАГ МОНГОЛБАНКНЫ САЛБАР

Буяннэмэхийн өргөн чөлөө-3, 7-р баг, Сайнцагаан сум,
Дундговь аймаг 48101, Утас/Факс: (976)-7059-3751

2026.06.30 № 11/22
танай _____-ны № _____-т

┌ ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН ┐
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Р.МӨНХТОГТОХ ТАНАА

Манай байгууллагаас болон арилжааны
банкуудаас “Шинэ хоршоо” хөдөлгөөнд олгосон
зээлийн эргэн төлөлт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайланд өгөх санал байхгүй болно.

ЗАХИРАЛ

С.БАТТӨМӨР



Activate Windows
Go to Settings to activate Wind

ДУА-2026/21-10/ШТА-ГА